



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

┌ Аргачлал шинэчлэн батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монгол Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Монгол Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний загвар, төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн загвар”-ыг гуравдугаар хавсралтаар, “Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар”-ыг тавдугаар хавсралтаар, “Монгол Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлэх саналын маягт, саналын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн маягт”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Аргачлал батлах тухай” Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167, Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү аргачлалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД



Ж.ЭНХБАЯР

152501000600

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 18
дугаар сарын 18-ны өдрийн 1/66 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН
ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан захиргааны байгууллага нь (цаашид “Холбогдох байгууллага” гэх) Улс болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний (цаашид “Хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэх) төслийг боловсруулахад энэхүү аргачлалыг баримтална.
- 1.2. Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актад үндэслэнэ.
- 1.3. Энэ аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.3.1. “үндэсний үр дүн” гэж улс оршин байх тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.2. “салбарын үр дүн” гэж үндэсний үр дүнг хангах тухайн салбарын тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.3. “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж төсвийн тухай хуулийн 4.1.36-д тодорхойлсныг;
 - 1.3.4. “төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” гэж салбарын үр дүнг хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний үндсэн үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.5. “хөтөлбөр” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.16-д тодорхойлсныг;
 - 1.3.6. “хөтөлбөрийн үр дүн” гэж төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг хангах хөтөлбөр хэрэгжсэнээр бий болох эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.7. “үндсэн үйл ажиллагаа” гэж төрийн байгууллагын зорилго, зорилтыг хангахад чиглэсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх багц арга хэмжээ;
 - 1.3.8. “төсөл” гэж хөтөлбөрийн үр дүн гарахад хувь нэмэр оруулахаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт эсвэл нэг удаагийн багц арга хэмжээ;
 - 1.3.9. “арга хэмжээ” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д тодорхойлсныг;
 - 1.3.10. “тархалтын хурд” гэж асуудлын сүүлийн 3-5 жилийн динамик өөрчлөлтийг гаргаж, өөрчлөлтийн дундаж утгыг.
- 1.4. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн загварыг тушаалын хоёрдугаар дугаар хавсралтаар батлуулна.
- 1.5. Монгол Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний загвар, төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн загварыг тушаалын гуравдугаар хавсралтад заасан загвар, дөрөв, тавдугаар хавсралтад заасан цаглаврын дагуу боловсруулна.

1.6. Улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлэх саналыг тушаалын зургаадугаар хавсралтад заасан загвар хүснэгтийн дагуу боловсруулна.

1.7. Холбогдох байгууллага нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг төсвийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.

1.8. Ажлын хэсэг нь өмнөх оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх санал, зөвлөмжтэй танилцаж төлөвлөгөөг боловсруулна.

1.9. Ажлын хэсэг нь холбогдох нөөцийн бэлэн байдлыг хангана.

1.9.1. Хүний нөөц;

1.9.2. Мэдээллийн нөөц;

1.9.3. Санхүүгийн нөөц.

1.10. Холбогдох байгууллага нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэгт төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулж болно.

Хоёр. Хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

2.1. Ажлын хэсэг нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд дараах мэдээллийг цуглуулна.

2.1.1. Өмнөх оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний урьдчилсан гүйцэтгэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээний тайлан;

2.1.2. Нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний хөгжил, засаглалын голлох үзүүлэлтүүд, тэдгээрийн дунд хугацааны таамаглал;

2.1.3. Дотоод, гадаад нөхцөл байдал, өөрчлөлтийн таамаглал;

2.1.4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн суурь мэдээлэл;

2.1.5. Улсын мөнгөний бодлогын суурь мэдээлэл;

2.1.6. Жендэрийн дүн шинжилгээ

2.2. Холбогдох байгууллага нь энэхүү аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан мэдээ, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийж, жилийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүнд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн Хөгжлийн жилийн төлөвлөгөөний танилцуулгад хавсаргана.

2.3. Холбогдох байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч нарт нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх болон Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн боловсруулахад нь зориулж дараах мэдээллээр хангана.

2.3.1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн боловсруулах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж);

2.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нар нь өөрийн харьяалах төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарын хариуцсан чиг үүргийн хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулна.

2.5. Төсвийн ерөнхийлөн захирагч нар нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн түвшинд тулгамдсан асуудал, түүний хамрах хүрээ, тархалтын хурдыг аймаг, нийслэл (сум, дүүрэг)-ээр ангилж гаргана.

2.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нар нь нөхцөл байдлын дүн шинжилгээг дараах мэдээлэлд тулгуурлан хийнэ.

2.6.1. Стратеги төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ;

2.6.2. Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ;

2.6.3. Сүүлийн гурван жилийн төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ;

2.6.4. Шаардлагатай тохиолдолд Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинээр тодорхойлох.

2.7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний санал нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна.

2.7.1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний санхүүжилтийн нийт дүнгийн өсөлт нь өнгөрсөн жилийн батлагдсан төсвийн 20 хувиас хэтрэхгүй байх;

2.7.2. Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байх;

2.7.3. Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон байх;

2.7.4. Төсөл, арга хэмжээ нь дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлсон хөтөлбөрийн үр дүнгийн арга замд нийцсэн байх;

2.7.5. Хариуцах эзэнтэй байх;

2.7.6. Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээний хувьд тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд зайлшгүй тусгах шаардлага, үндэслэл, тооцоо судалгааг ирүүлэх;

2.7.7. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан байх;

2.7.8. Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний саналыг хөтөлбөр тус бүрээр ач холбогдлоор нь эрэмбэлж, өртгийн тооцоог үндэслэлтэй хийсэн байх.

Гурав. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг төлөвлөх

3.1. Тухайн жилийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг дунд хугацааны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, холбогдох байгууллагаас Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналд үндэслэн тушаалын гуравдугаар хавсралтын дагуу боловсруулна.

3.2. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийг нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн асуудлын хамрах хүрээ, тархалтын хурд, үр дагавраар үнэлж, эрэмбэлнэ.

3.3. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүнг Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн дөрвөн түвшнээр уялдуулан төлөвлөнө.

3.4. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг энэхүү тушаалын хоёрдугаар дугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

- 3.4.1. “Үндэсний үр дүн” баганад дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт үндэслэсэн Үндэсний үр дүнг бичнэ.
- 3.4.2. “Салбарын үр дүн” баганад дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт үндэслэсэн Салбарын үр дүнг бичнэ.
- 3.4.3. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” баганад дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт үндэслэсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг бичнэ.
- 3.4.4. “Хөтөлбөрийн үр дүн” баганад дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт үндэслэсэн Хөтөлбөрийн үр дүнг бичнэ.
- 3.4.5. “Бодлогын үндэслэл” баганад үр дүнд хамаарах урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтын дугаарыг бичнэ.
- 3.4.6. “Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний үндэслэл” баганад холбогдох хуулийн заалт болон дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн холбогдох дугаарыг бичнэ.
- 3.4.7. “Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ” баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүн тус бүрээр төлөвлөнө.
- 3.4.8. “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тодорхойлж бичнэ.
- 3.4.9. Суурь түвшин”, “Суурь он” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, урьдчилсан гүйцэтгэлийн хүрсэн түвшинд үндэслэн суурь түвшин, оныг тодорхойлж бичнэ.
- 3.4.10. “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшинд үндэслэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.
- 3.4.11. “Нийт санхүүжилтийн дүн”, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт” баганад хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах нийт санхүүжилтийн хэмжээ, тухайн жилд шаардагдах санхүүжилтийн хэмжээг тооцож оруулна.
- 3.4.12. “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал” баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг дараах жагсаалтаас сонгож оруулна.
- 3.4.12.1. Улсын төсөв
 - 3.4.12.2. Орон нутгийн төсөв
 - 3.4.12.3. Гадаадын зээл
 - 3.4.12.4. Гадаадын тусламж
 - 3.4.12.5. Гадаадын хөрөнгө оруулалт
 - 3.4.12.6. Дотоодын хөрөнгө оруулалт
 - 3.4.12.7. Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас
 - 3.4.12.8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ
 - 3.4.12.9. Бусад эх үүсвэр

3.4.13. “Үндсэн хариуцагч” баганад үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээн ажиллах субъектийг тодорхойлж бичнэ.

3.4.14. “Хамтран хариуцагч” баганад үр дүнгийн тодорхой хэсгийг биелүүлэхийн төлөө үндсэн хариуцагчтай хамтран ажиллах субъектийг тодорхойлж бичнэ.

**Дөрөв. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний
үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт,
зорилтот түвшинг тодорхойлох**

4.1. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтын хоёрдугаар хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

4.1.1. “Салбар/ТЕЗ/Хөтөлбөрийн нэр” баганад тухай үр дүнг хариуцах салбар, Төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн нэрийг бичнэ.

4.1.2 “Үр дүн” баганад энэхүү тушаалын хоёрдугаар дугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтэд тодорхойлсон үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнг хуулж бичнэ.

4.1.3. “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад үр дүнг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж бичнэ.

4.1.4. “Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа” баганад Тогтвортой хөгжлийн зорилгын холбогдох дугаарыг бичнэ.

4.1.5. “Суурь түвшин”, “Суурь он” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, урьдчилсан гүйцэтгэлийн хүрсэн түвшинд үндэслэн суурь түвшин, оныг тодорхойлж бичнэ.

4.1.6. “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшинд үндэслэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

4.1.7. “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдлыг өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлж бичнэ.


**Тав. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаар
Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдээлэл
хүргүүлэх, санал авах, зөвшилцөх**

5.1. Холбогдох байгууллага нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллага тус бүрээр хүргүүлнэ.

5.2. Холбогдох байгууллага нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд талуудаас санал авч, хариу мэдэгдэнэ.

5.3. Холбогдох байгууллага нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд туссан үр дүнгийн зорилтот түвшинг тодорхойлохдоо талуудтай зөвшилцөн эцэслэнэ.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025
оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 106
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ЗАГВАР**

Ерөнхий мэдээлэл:

Жич: Энэ хэсэгт тухайн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн онцлогийг бичнэ.


Тэргүүлэх чиглэл:

Жич: Энэ хэсэгт тухайн жилийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж бичнэ.

Улсын Шадар сайд бөгөөд
төрийн сайдын 2025 оны
12-ны өдрийн 116 дугаар
уравдугаар хавср

[illegible][illegible]

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 12
дугаар сарын 18-ны өдрийн 1/16 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт



НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЦАГЛАВАР

Хүснэгт 1. Эдийн засаг, хөгжлийн яамны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах цаглавар


№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах	Өмнөх оны 12 сарын 01-ний дотор
2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах	Өмнөх оны 12 сарын 05-ны дотор
3	Энэ аргачлалын 2.1.1-2.1.5-д заасан өгөгдөл, мэдээллийг холбогдох талуудаас авах	Өмнөх оны 12 сарын 15-ны дотор
4	Нөхцөл байдлын урьдчилсан дүн шинжилгээ хийх	Өмнөх оны 12 сарын 15-ны дотор
5	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах санал авах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж)-ыг хүргүүлэх	Өмнөх оны 12 сарын 15-ны дотор
6	Шаардлагатай тохиолдолд холбогдох талуудад арга зүйн сургалт, зааварчилгаа өгөх	1 сарыг 05-ны дотор
7	Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал авах	1 сарын 15-ны дотор
8	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж дуусгах	2 сарын 01-ний дотор
9	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж дуусгах	2 сарын 20-ны дотор
10	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад танилцуулж, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах	2 сарын 28-ны дотор
11	Холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг үндэслэлтэй тохиолдолд төсөлд тусгах	3 сарын 05-ны дотор
12	Төслийг сайдад танилцуулах	3 сарын 05-ны дотор
13	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд өгсөн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагуудад мэдээлэх	3 сарын 15-ны дотор
14	Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга боловсруулах	3 сарын 20-ны дотор
15	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах	3 сарын 25-ны дотор
16	Ажлын хэсэг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар	4 сарын 01-ний дотор

санал, зөвлөмж боловсруулж оролцогч талуудад нэгдсэн байдлаар хүргүүлэх	
---	--

Хүснэгт 2. Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагын Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах цаглавар

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах ажлын хэсэг байгуулах	Өмнөх оны 12 сарын 10-ны дотор
2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах	Өмнөх оны 12 сарын 16-ны дотор
3	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх	Өмнөх оны 12 сарын 20-ны дотор
4	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авах маяг, заавар (удирдамж)-ыг боловсруулж хүргүүлэх	Өмнөх оны 12 сарын 22-ны дотор
5	Шаардлагатай тохиолдолд холбогдох талуудад арга зүйн сургалт, зааварчилгаа өгөх	Өмнөх оны 12 сарын 25-ны дотор
6	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах	1 сарын 01-ний дотор
7	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж дуусгах	1 сарын 05-ны дотор
8	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах	1 сарын 10-ны дотор
9	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг ЭЗХЯ-нд хүргүүлэх	1 сарын 15-ны дотор
10	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал өгөх	2 сарын 28-ны дотор
11	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж холбогдох талуудад хүргүүлэх	3 сарын 05-ны дотор

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн
засаг, хөгжлийн сайдын 2025 оны 12
дугаар сарын 18-ны өдрийн 106 дугаар
тушаалын тавдугаар хавсралт



**ХОЁР. АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХ ЦАГЛАВАР**

Хүснэгт 3. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах цаглавар

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргаар батлуулна.	4 сарын 01-ний дотор
2	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд аймаг, нийслэлийн ЗДТГ нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ.	4 сарын 10-ны дотор
3	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах санал авах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж)-ыг хүргүүлэх	4 сарын 15-ны дотор
4	Холбогдох захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Аймаг, нийслэлийн ЗДТГ-т ирүүлнэ.	6 сарын 01-ний дотор
5	Аймаг, нийслэлийн ЗДТГ нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулна.	7 сарын 05-ны дотор
6	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг ЭЗХЯ-д санал авахаар хүргүүлэх	7 сарын 27-ны дотор
7	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад танилцуулж, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах	8 сарын 05-ны дотор
8	ЭЗХЯ-аас ирүүлсэн саналыг Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгах	8 сарын 15-ны дотор
9	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг тухайн шатны Засаг даргад танилцуулах	8 сарын 20-ний дотор
10	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэх	8 сарын 25-ний дотор
11	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн мэдүүлэх	09 сарын 01-ний дотор

улсын Шадар сайд бөгөөд
ын засаг, хөгжлийн сайдын
угаар сарын 18-ны өдрийн
ын зургаадугаар хавсралт

**Хүснэгт 1. МОНГОЛ УЛСЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН
ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ИРҮҮЛЭХ САНАЛЫН МАЯГТ**

[illegible]

Хүснэгт 2. МОНГОЛ УЛСЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ИРҮҮЛЭХ САНАЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН МАЯГТ

[illegible]

